Улаанбаатар хотын үсчид, маникюрчид, шивээсчдийн дунд Гепатит В, С вирусийн тархалт тодорхойлох, мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх нь

Ж.Ариунтуяа[1], О.Баярсайхан[1,2], Д.Даваадорж[1]

[1]АШУҮИС, АУС, Хоол боловсруулах эрхтэн судлалын тэнхим
[2] АШУҮИС, Төв эмнэлэг, Дурангийн тасаг
Цахим шуудан: ariuka04033@gmail.com, Утас: 99140814

Түлхүүр үг:
Мэдлэг
Хандлага
Гепатит В
Гепатит С

Товч утга:
Үндэслэл: Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тооцоолсноор дэлхий даяар 350 сая гепатит В вирус, 170 сая гепатит С вирус өвчлөлтэй байна. Манай улсад элэгний эст өмөнгийн шалтгааны 46% нь гепатитийн С вирус, 35% нь гепатитийн В вирус,14% нь В,С вирусийн хавсарсан халдвартай болохыг судалгаачид тогтоосон байна. Монгол улс 100,000 хүн амд ногдох элэгний эст өмөнгийн шалтгаант нас баралтаар дэлхийд 1-р байранд байгаа бөгөөд энэ нь дэлхийн дунджаас 8 дахин их бөгөөд манай улс Гепатит В вирусийн халдвар нутагшмал тархсан оронд тооцогддог.ГВВ болон ГСВ-н халдвар нь хөгжиж буй орнуудад үсчид, шивээсчид, маникюрч нарын мэргэжлээс шалтгаалах эрсдэлд хамаарч байна.Манай улсад үсчид, шивээсчид, маникюрч нарын дунд ГВВ болон ГСВ-ийн тархалт болон мэдлэг, хандлага, дадлын талаар хийгдсэн судалгааны ажил одоогоор үгүй байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон. **Зорилго:** Улаанбаатар хотын үсчид, шивээсчид, маникюрч нарын дундах ГВВ, ГСВ-ийн тархалтын түвшинг тодорхойлж, мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх. **Арга, аргачлал:** Ажиглалт судалгааны нэг агшингийн загварыг ашиглан Үсчин, гоо сайханч, шивээсчний мэргэжлээр ажилладаг 361 хүнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч судалгаанд хамруулсан. **Үр дүн:** Судалгаанд оролцсон хүмүүсийн 84% нь эмэгтэй, 16% нь эрэгтэй байв.Тэдний 61% нь гараа зүсэх, шалбалах, хайчлах, зүүнд хатгуулах зэргээр эрсдэл бүхий гэмтэл авсан болох нь тодорхойлогдлоо.Оролцогчдын 52% нь урьд өмнө нь Гепатит В,С вирусийн шинжилгээ өгч байснаас 6% нь Гепатит вирусийн архаг халдвар оношлогдож хоол боловсруулах эмчийн хяналтанд байдаг байна. Шинжилгээгээр 8.6% HCV, 6.7% нь HbsAg халдвартай байв.Түүнчлэн Гепатит В вирусийн урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдсан хувь 17% эзэлж байв. ГВВ болон ГСВ нь вируст өвчин гэдгийг 68%, цусаар дамжих боломжтойг 76%, багаж хэрэгсэлээр дамжих боломжтойг 84%, элэгний хатуурал үүсгэдэг гэдгийг 69% нь мэддэг байна. Судалгаанд хамрагдагсдын нэг удаагийн хэрэгслийн хэрэглээ 77% байна. **Дүгнэлт:** Үсчид, гоо сайханчид, шивээсчдийн дунд ГВВ, ГСВ-н халдварын тархалт 15.3% байна. Үсчид, гоо сайханчид, шивээсчдийн дунд мэдлэг, дадал хангалттай байна.

Үндэслэл: Дэлхий даяар 350 сая хүн Гепатит С вирусийн,170 сая хүн В вирусийн халдвартай байна. Монгол улс 100.000 хүн амд ногдох элэгний эст өмөнгийн шалтгаант нас баралтаар дэлхийд 1-р байранд байгаа бөгөөд энэ нь дэлхийн дунджаас 8 дахин их бөгөөд Гепатит В вирусийн халдвар нутагшмал тархсан оронд тооцогддог[1]. Манай улсад элэгний эст өмөнгийн шалтгааны 46% нь гепатит С вирус, 35% нь гепатит В вирус, 14% нь В,С вирусийн хавсарсан халдвартай болохыг судлаачид тогтоосон байна.Элэгний эст өмөнгийн өвчлөл насны бүлгээр авч үзвэл 65 түүнээс дээш насанд 100000 хүн амд 143.8, 45-

65 насныханд 35.2 бүртгэгдсэн[8]. Турк, Ганна, Энэтхэг, Морокко, Бангладеш зэрэг улсуудад Үсчдийн дундах Гепатитын халдварын талаарх судалгаа хангалттай хийгдэж ГВВ болон ГСВ-н халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, хөндлөнгөөс ажиглах стратеги боловсруулж үсчид өөрсдийгөө болон үйлчлүүлэгдийнхээ эрсдлийг бууруулах нь чухал хэмээн онцолсон байна[5-7]. Манай улсад тэдний ажлын байран дахь ГВВ болон ГСВ-ийн халдвар хяналт, сэргийлэлтийн талаар хийгдсэн судалгааны ажил одоогоор үгүй бөгөөд гоо сайхны салбар дахь мэдлэг, хандлага, мэдээллийг судлах нь энэхүү судалгааг эхлүүлэх үндэслэл болсон.

Зорилго: Улаанбаатар хотын үсчид, шивээсчид, маникюрч нарын дунд Гепатит В, С вирусийн тархалтын түвшинг2 тодорхойлж, үсчид, шивээсчид, маникюрч нарын ГВВ, ГСВ-ийн мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх.

Зорилт:

1. Судалгаанд хамрагдагсдын дунд ГВВ болон ГСВ-н халдварын тархалтыг тодорхойлох
2. ГВВ болон ГСВ-н халдварын талаарх мэдлэгийг үнэлэх, ажлын байран дахь аюулгүй ажиллагааг үнэлэх

Арга, аргачлал: Бид энэхүү судалгааг гүйцэтгэхдээ АШУҮИС-ийн Судалгааны Ёс Зүйн Хяналтын хорооны 2022/3-06 тоот хурлаар орон ёс зүйн зөвшөөрөл авсан. Судалгааг нэг агшингийн загвараар АШУҮИС Төв эмнэлгийг түшиглэн хийсэн. Судалгааг Улаанбаатар хотод 2022 оны 5 дугаар сараас 2022 оны 9 дүгээр сар хүртэлх хугацаанд үсчин, гоо сайханчаар ажилладаг 361 хүнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч судалгаанд хамруулсан.Судалгааны статистик боловсруулалтыг Microsoft Excel 2010, STATA-15 программ хангамжийг ашиглан үзүүлэлтийн дундаж, стандарт хазайлт, чанарын мэдээллийн ялгаатай эсэхийг Пирсоны Хи Квадрат, статистик ялгааг $P<0.05$ утгатай тохиолдолд статистик үнэн магадлалтай гэж тооцсон.

Үр дүн: Судалгаанд 20-60 насны нийт 361 оролцогчид хамрагдсанаас эмэгтэй 84% нь (n=58), эрэгтэй 16% (n=303) нь байв. Тэдний 69% нь 10 хүртэлх жил, 18% нь 10-20 жилийн турш, 12% нь 20-с дээш жил ажилласан туршлагатай байв. Гоо сайхны багаж хэрэгсэл ариутгах, халдваргүйжүүлэлт зэрэг дадлын үнэлэв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Багаж хэрэгсэл ариутгах, халдваргүйжүүлэлтийн талаарх үнэлгээ

Асуулт	Тийм (n)	Үгүй (n)
Та хэрэглэсэн багажаа усаар угаадаг уу?	210 (58.17)	151 (41.83)
Та хэрэглэсэн багажаа 70%-н спиртээр арчдаг уу?	296 (81.99)	65 (18.01)
Та хэрэглэсэн багажаа ариутгалын уусмалаар угаадаг уу?	275 (76.18)	86 (23.82)

Оролцогчдын 52% (n=187) Гепатит В,С вирусийн шинжилгээ өгч байснаас 6% (n=22) Гепатит вирусийн халдвар оношлогдож Гастроэнтерологийн эмчийн хяналтанд байдаг болох нь асуумжаар тогтоогдлоо. Гепатит В,С вирусийн шинжилгээнд тогтмол хамрагдах шаардлагатай гэдэгтэй оролцогчдын 80% (n=288) нь санал нийлж байв. Гепатит В вирусийн урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдалт 17% (n=62) нь байна. Оролцогчдын шинжилгээнд хамрагдаж байсан эсэх, халдвар оношлогдсон байдал, урьдчилан сэргийлэлт, мэдээлэл авсан эсэх зэрэг хандлагыг үнэлэв (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Оролцогчдын ГВВ, ГСВ-н халдварын тархалт болон вакцинжуулалт

Асуулт	Тийм (n)	Үгүй (n)
Та өмнө нь ГВВ, ГСВ илрүүлэх шинжилгээнд хамрагдаж байсан уу ?	187 (51.8)	174 (48.2)
Урьд өмнө нь ГВВ болон ГСВ оношлогдож байсан уу ?	22 (6.09)	339 (93.91)
Та Гепатит В вирусийн вакцинд хамрагдаж байсан уу?	62 (17.17)	299 (82.83)
Та ГВВ, ГСВ-н талаар мэдээлэл, радио, телевизээр сонсож мэдээлэл авч байсан уу ?	192 (53.19)	169 (46.81)
Та ГВВ, ГСВ-н халдвар илрүүлэх шинжилгээнд тогтмол хамрагдах шаардлагатай гэдэгтэй санал нийлэх үү ?	288 (79.78)	73 (20.22)

Оролцогчдын 33% (n=118) нь мэдлэгийн оноо 75%-аас дээш буюу сайн үнэлгээ авсан. Мэдлэгийн түвшинг илэрхийлэв (Хүснэгт3).

Хүснэгт 3. ГВВ, ГСВ-н талаарх мэдлэгийн түвшин

Асуулт	Тийм (n)	Үгүй (n)
Гепатит В, С вирус нь вируст өвчин гэдгийг мэдэх үү ?	247 (68.42)	114 (31.58)
Гепатит В, С вирус цусаар дамждаг үү?	275 (76.18)	86 (23.82)
Гепатит В, С вирус бэлгийн зан үйлээр дамждаг үү?	135 (37.4)	226 (62.6)
Гепатит В, С вирус ариутгаагүй багаж хэрэгслээр дамждаг үү?	301 (83.38)	60 (16.62)
Сахлын хутганы ир, үсний машин, хумсны мах авагч, цахилгаан дрилл зэргээр вирус дамждаг үү?	304 (84.21)	57 (15.79)
Гепатит В, С вирус нь элэгний хатуурал, хорт хавдар үүсгэх гол шалтгаан гэдгийг мэдэх үү?	250 (69.25)	111 (30.75)
Та Гепатит В, С вирусийн эмчилгээний талаар мэдэх үү ?	81 (22.44)	280 (77.56)

Дүгнэлтээс өөрийн мэргэжил халдварын тархалтанд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдэгтэй 84% нь санал нэгдэж байна. Судалгаанд хамрагдагсдын нэг удаагийн хэрэгслийн хэрэглээ 77% байна.

Хэлцэмж: Монгол улсын нийт хүн амын дунд 2008 онд хийгдсэн судалгаагаар Гепатитийн С вирусын халдвар 15.6%,С вирусын генотип 1b 98.8%-д тодорхойлогдсон[2]. Бангладеш улсын судлаач Mb Abdul Mumit Sarkar (2020) нарын судалгаанд Гепатит В, С вирусийн халдвар дамжих, урьдчилан сэргийлэх талаарх үсчингүүдийн мэдлэг, хандлага, дадлын өнөөгийн байдалт сэдэвт 403 үсчин хамрагдсан судалгаанд 12% нь ГВВ эсрэг вакцинд хамрагдсан, 57% нь үйлчлүүлэгчид хэрэглэсэн багажаа ариутгалын уусмалаар цэвэрлэсэн нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байна[3]. Sumaira Tasleem (2021) нарын судалгаагаар 85% нь гоо сайхны мэргэжил нь өвчний тархалтанд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдэгтэй санал нийлж буй гэсэн судлаачдын үр дүнтэй бидний үр дүн нийцэж байна[4]. Нэг удаагийн хэрэгслийн хэрэглээ болон ариутгал халдваргүйжүүлэлтийн хувь олон улсын эрдэмтэн судлаач нарын хийсэн судалгаатай харьцуулаад харвал үр дүнгийн хувьд ижил төстэй байдал харагдаж байна[10-11].

Дүгнэлт: Үсчид, гоо сайханчид, шивээсчдийн дунд гепатит тархалт их учир цус биологийн шингэнээр дамжих халдвараас сэргийлэх, антисептик, асептикын мэдлэгийг дээшлүүлэх стратеги шаардлагатай байна. Түүнчлэн үсчид, гоо сайханчид, шивээсчид нь ГВВ-ийн эсрэг урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдалтын хувь бага байх нь Гепатитаар өвчлөх эрсдлийг улам ихэсгэж байна.

Ном зүй:

1. *Монгол Улсын Засгийн газрын 112 тоот тогтоол 2017-4-12 ‘’”Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр*
2. *Mongolian Journal of gastroenterology and hepatology. June. 2017.*
3. *Md AbduMumit Sarkar [6]MadhusudanSaha [b]Mohammad Naymul-Hasan[c]BirendraNathSaha[d] AvijitDas. Current status of knowledge, attitudes, and practices of barbers regarding transmission and prevention of hepatitis B and C virus in the north-west part of Bangladesh: A cross-sectional study in 2020. Public Health in Practice. Vol2. Nov 2021.*
4. *Md AbduMumit Sarkar [6]MadhusudanSaha [b]Mohammad Naymul-Hasan[c]BirendraNathSaha[d] AvijitDas. Current status of knowledge, attitudes, and practices of barbers regarding transmission and prevention of hepatitis B and C virus in the north-west part of Bangladesh: A cross-sectional study in 2020. Public Health in Practice. Vol2. Nov 2021.*
5. *Yasir Waheed, Umar Saeed,Sher Zaman Safi, Waqas Nasir Chaundhry, Ishtaiq Qadri Awareness and risk factors associated with barbers in transmission of hepatitis B and C from Pakistani population: barber's role in viral transmission. Asian Biomedicine. Vol 4. July 2010. Pages 435-442.*
6. *Amir Abdul Khaliq, Raymond A Smego, jun. Barber shaving and blood-borne disease transmission in developing countries. SAMJ. Vol 95. February 2005. No2.*
7. *Sumaira-Tasleem-, Humaira Imam, Hafiz Muhammad Irfan, Tahira Imam and Muhammad Imran. A study regarding awareness and spread of Hepatitis B and C among barbers and beauty parlors working in DG Khan. Journal of Community Medicine and Health Education. Vol11(4).*
8. *Эрүүл мэндийн үзүүлэлт 2020*
9. *Haruki Komatsu, Ayano Inui, Enkhtaivan Odmaa, Yoshinori Ito, Shuichiro Umetsu, Tsuyoshi Sogo, Tomoo Fujisawa. A novel approach for the diagnosis and treatment of chronic hepatitis B virus infection using nails and hair.*
10. *Tahereh Khairkhah, Ayat Shamsa, Azam Roohi, Jalal Khoshnoodi, Fatemeh Vand-Rajabpour, Mina Tabrizi, Saeed Zarei, Forough Golsaz-Shirazi, Fazel Shokri. Analysis of Knowledge, Attitudes and Prevalence of Hepatitis B and C Seromarkers Among Barbers In Tehran in 2020. International Monthly Journal in the Field of Hepatology. Vol 16. August 13, 2016.*
11. *Mohamed Mutochekuh and Kwaku Kwarteng . Knowledge and occupational hazards of barbers in the transmission of hepatitis B and C was low in Kumasi, Ghana. The Pan African Medical Journal. 2015 Mar 18.*

Assessing knowledge, attitude, and practice of barbers, beauticians and tattoo artists regarding transmission of Hepatitis B and Hepatitis C virus in Ulaanbaatar city

Ariuntuya J[1], Bayarsaikhan O[1,2], Davaadorj D[1]

[1]Department of Gastroenterology, School of Medicine, MNUMS
[2]Department of Endoscopy, Central hospital, MNUMS
E-mail: ariuka04033@gmail.com, Tel: +976-99140814

Background: According to World Health Organization,350 million people worldwide are chronically infected with Hepatitis B virus and 170 million people are infected with Hepatitis C virus. Studies in Mongolia have shown that within the cause of hepatocyte carcinoma 45% is Hepatitis C, 35% is Hepatitis B and 14% is co-infections with Hepatitis B, C. Mongolia ranks first in the world in terms of death due to hepatocyte carcinoma per 100,000 population, which is 8 times higher than the world average, and is considered a country where Hepatitis B virus infection is endemic. Moreover, HBV and HCV infections have also been implicated as an occupational hazard of the barbers, beauticians and tattoo artists in developing countries. Data on the infection, knowledge, attitude and practice of barbers, beauticians and tattoo artists about HBV and HCV in Mongolia are lacking. Hence the study was aimed to investigate them.

Materials and Methods: To estimate infection rate and to assess knowledge, attitude, practice among barbers, beauticians, and tattoo artists regarding Hepatitis B and Hepatitis C infection in Ulaanbaatar city of Mongolia. 361 people working as barbers, beauticians, and tattoo artists will be selected and subjected to the study by random sampling using a cross-sectional study of observational research.

Results: 84% of participants are women,16% of participants are men.61% of them had some kind of risky injury by accidentally cutting, scratching their hands, or poking them with needles while working. Among the participants, 52% were tested for Hepatitis B and C viruses, and 6% were diagnosed with Hepatitis virus infection and are under the supervision of a gastroenterologist. Blood test showed that 8.6% of them were infected by HCV and 6.7% of them were infected by HBV.17% were vaccinated against Hepatitis B virus. Among participants, 68% of them knew that HBV and HCV are viral diseases, 76% of them knew that it can be transmitted through blood, 84% of them knew that it can be transmitted through unsterilized tools, 69% of them knew that it can cause cirrhosis and liver cirrhosis. The use of disinfection and disposable tools in barbershops and beauty salons is 77%.

Conclusion: Infection rate of HBV and HCV among barbers, beauticians, and tattoo artists is 15.3%. Knowledge and practice of Hepatitis B and Hepatitis C infection among barbers, beauticians, and tattoo artists are sufficient.

Keyword: Knowledge, Attitude, Hepatitis B, Hepatitis C